



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2014 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэг, Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. “Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийг урамшуулах журам”-ыг нэгдүгээр, “Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийг урамшуулах үзлэгийн оношлогоо, шинжилгээний багц, төлбөрийн хэмжээ”-г хоёрдугаар, “Даатгуулагчийг урамшуулах эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулах эмнэлгүүдийг сонгох журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Урамшуулалд зарцуулах хөрөнгийг эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын жил бүрийн төсөвт тусгах, эмнэлгүүдийг сонгох, батлагдсан журмыг сурталчлах, болзол, нөхцлийг хангасан даатгуулагчдыг урамшууллын үйлчилгээнд тэгш, хүртээмжтэй хамруулах, урамшууллын тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих ажлыг зохион байгуулахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Ц.Уртнасан/-т даалгасугай.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /М.Саранчимэг/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2009 оны 38 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ЭРДЭНЭ

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2014 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 1.7 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИЙГ УРАМШУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ жил бүр тогтмол төлсөн боловч дараалсан гурван жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ аваагүй даатгуулагчийг эрүүл мэндийн бүрэн үзлэгт нэг удаа хамруулж, урамшуулах /цаашид “эрүүл мэндийн урамшуулах үзлэг” гэх/, даатгуулагчийг өвчлөхөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн улмаас үүсэх санхүүгийн эрсдэлээс хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ жил бүр тогтмол төлсөн хугацаа”-нд даатгуулагчийн эрүүл мэндийн урамшуулах үзлэгт орох хүсэлтээ гаргахын өмнөх 3 жилийн турш хуулиар тогтоосон хугацаанд шимтгэлээ тогтмол, бүрэн төлсөн хугацааг хамааруулна. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсэгт зааснаар даатгуулагч шимтгэлээ нөхөн төлсөн тохиолдлыг энэ хугацаанд тооцохгүй.

1.3. Эрүүл мэндийн урамшуулах үзлэгийг “Эрүүл мэндийн урамшуулах үзлэг зохион байгуулах эмнэлгүүдийг сонгох журам”-ын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газраас сонгон шалгаруулсан өмчийн бүх хэвшлийн эмнэлгүүд зохион байгуулна.

1.4. Эрүүл мэндийн урамшуулах үзлэгийн даатгалын сангаас нэг даатгуулагчид төлөх төлбөрийг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж байгаа Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар баталсан хэмжээгээр тооцно.

1.5. Эрүүл мэндийн урамшуулах үзлэг нь эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээнд хамаарахгүй. Өөрөөр хэлбэл даатгуулагчийн эрүүл мэндийн урамшуулах үзлэгт хамрагдсан жил нь энэ журмын 1.2 дахь хэсэгт заасан хугацаанд хамаарч даатгуулагч дахин эрүүл мэндийн урамшуулах үзлэгт орох боломжтой.

### Хоёр. Даатгуулагч эрүүл мэндийн урамшуулах үзлэгт хамрагдах нөхцөл

2.1. Даатгуулагч нь дараах нөхцлийг хангасан тохиолдолд эрүүл мэндийн урамшуулах үзлэгт хамрагдана. Үүнд:

2.1.1. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ хугацаанд нь тогтмол төлж, эрүүл мэндийн даатгалын гэрчилгээгээ баталгаажуулсан, 16-аас дээш настай даатгуулагч байх;

2.1.2. Эрүүл мэндийн урамшуулах үзлэгт хамрагдах хүсэлтээ гаргахын өмнөх дараалсан гурван жилд эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж, үйлчилгээний зардлын төлбөр гаргуулаагүй байх;

### **Гурав. Даатгуулагчийн эрх, үүрэг**

3.1. Энэ журмын 2.1 дэх хэсэгт заасан нөхцлийг хангасан даатгуулагч нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлээсээ хамааран эрүүл мэндийн урамшуулах үзлэгийн оношлогоо, шинжилгээний багцаас сонгон хамрагдах эрхтэй.

3.2. Даатгуулагч эрүүл мэндийн урамшуулах үзлэгт хамрагдах эрхтэй эсэхээ Нийгмийн даатгалын ерөнхий газрын ndaatgal.mn вэб сайт болон харьяа нийгмийн даатгалын байгууллагад хандан шалгуулж, эрх үүссэн тохиолдолд тухайн хэлтэс эрүүл мэндийн даатгалын гэрчилгээнд нь “урамшууллын эрх” гэсэн дардсаар баталгаажуулж өгнө.

3.3. Даатгуулагч эрүүл мэндийн даатгалын гэрчилгээндээ “урамшууллын эрх” гэсэн тэмдэглэл хийлгэснээс хойш 30 хоногийн дотор урамшууллын тусламж, үйлчилгээ үзүүлэхээр Нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан эмнэлгүүдээс сонгож эрүүл мэндийн урамшуулах үзлэгт хамрагдана.

3.4. Даатгуулагч эрүүл мэндийн урамшуулах үзлэгт хамрагдахдаа дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:

- 3.4.1. эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ;
- 3.4.2. цахим үнэмлэх;
- 3.4.3. амбулаторийн үзлэгийн карт.

### **Дөрөв. Даатгуулагчийг урамшуулах үзлэгийн үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн хүлээх үүрэг**

4.1. Даатгуулагчид эрүүл мэндийн урамшууллын тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэг нь Нийгмийн даатгалын байгууллагатай эрүүл мэндийн даатгалын гэрээ байгуулсан байна.

4.2. Эрүүл мэндийн урамшуулах үзлэгийн эрх үүссэн даатгуулагчийн мэдээллийг ndaatgal.mn вэб сайт болон эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ, түүнд бичигдсэн “урамшууллын эрх” тэмдэглэл, тамга, цахим үнэмлэхийг нь үндэслэн эрүүл мэндийн урамшуулах үзлэгийн үйлчилгээг нэмэлт төлбөргүйгээр чанартай, түргэн шуурхай үзүүлнэ.

4.3. Эмнэлэг нь тухайн сард эрүүл мэндийн урамшуулах үзлэгт хамрагдсан даатгуулагчдын мэдээллийг Эрүүл мэндийн сайдын 2010 оны 17 дугаар тушаалаар баталсан “Амбулаториор үзүүлсэн тусламж, үйлчилгээ” хүснэгт /АМ-1А маягт/-ээр амбулаторийн тусламж, үйлчилгээнээс тусад нь гаргаж цаасаар болон файлаар, төлбөрийн нэхэмжлэлийн хамт харилцагч нийгмийн даатгалын байгууллагад дараа сарын 10-ны дотор ирүүлнэ.

4.4. Энэ журмаар тогтоосон нөхцлийг зөрчин иргэд /даатгуулагчдыг урамшуулах үзлэгт оруулсан тохиолдолд даатгалын сангаас төлбөр олгохгүй. Энэ тохиолдолд гарсан зардлыг буруутай эмнэлэг, эмч, мэргэжилтэн хариуцна.

4.5. Эмч урамшуулах үзлэгт хамрагдсан даатгуулагчийн оношлогоо, шинжилгээний хариуг үндэслэн амбулаторийн картанд нь дүгнэлт бичиж өгнө.

4.6. Иргэний эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулсан булан, самбар ажиллуулах замаар даатгуулагч /иргэд/-д даатгалын ач холбогдлыг ойлгуулах арга хэмжээг зохион байгуулна.

### **Тав. Нийгмийн даатгалын байгууллагын үүрэг**

5.1. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь “Даатгуулагчийг урамшуулах үзлэг зохион байгуулах эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ын дагуу эмнэлгүүдийг сонгон шалгаруулж шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор нийтэд мэдээлнэ.

5.2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын сонгон шалгаруулсан эмнэлгүүдтэй төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагууд гэрээ байгуулна.

5.3. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн төв нь энэ журмын 2.1 дэх хэсэгт заасан нөхцлийг хангасан даатгуулагчийн мэдээллийг регистрийн дугаараар шалгах, мэдээллээр хангах, хяналт тавих нөхцлийг бүрдүүлсэн програм хангамжийг боловсруулан, мэдээллийг жил бүрийн 03 дугаар сарын 25-ны дотор шинэчлэн гаргана.

5.4. Нийгмийн даатгалын хэлтсүүд урамшуулалд хамрагдах хүсэлт гаргасан даатгуулагчийн мэдээллийг [ndaatgal.mn](http://ndaatgal.mn) вэб сайтаас шалгаж, эрх үүссэн даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын гэрчилгээний тухайн жилийн хуудасны дээд талд “*урамшууллын эрх*” гэсэн дардсаар баталгаажуулна.

5.5. Энэ журмын 3.2-т заасан баталгаажилтыг аймагт Эрүүл мэндийн даатгалын алба, дүүрэгт Үйлчилгээний алба тус тус эрхлэн гүйцэтгэнэ.

5.6. Нийгмийн даатгалын хэлтэс нь “*урамшууллын эрх*”-ээ баталгаажуулсан даатгуулагчдын мэдээллийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газарт сар бүрийн 15, 30-ны өдрүүдэд ирүүлнэ.

5.7. Эмнэлгээс ирүүлсэн даатгуулагчийг урамшуулах үзлэгийн зардлын төлбөрийн нэхэмжлэлийг даатгуулагч бүрээр шалган, мэдээллийн санд бүртгэсний үндсэн дээр тухайн эмнэлгийн нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлбөрийг шилжүүлнэ.

5.8. Эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлах ажлыг эмнэлгүүдтэй хамтран зохион байгуулна.

### **Зургаа. Хариуцлага**

6.1. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд буруутай байгууллага, албан тушаалтан, даатгуулагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Нийгмийн даатгалын үндэсний  
зөвлөлийн 2014 оны 05 дугаар  
сарын 28-ны өдрийн /7 тоот  
тогтоолын хоёрдугаар хавсралт



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИЙГ УРАМШУУЛАХ  
ҮЗЛЭГИЙН ОНОШЛОГОО, ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДҮГЭЭР БАГЦ**

№		ҮЗЛЭГ ШИНЖИЛГЭЭ		ДААТГУУЛАГЧИЙН ХҮЙС			
				эрэгтэй	эмэгтэй		
1	1	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ	ЦЕШ, цусны бүлэгнэлт, цагаан эс тоолох /тромбоцит бүхий 22 үзүүлэлт/	+	+		
2	2	Шээсний ерөнхий шинжилгээ	Хувийн жин, өнгө, хэмжээ, уураг, сахар, улаан ба цагаан эс, эпители бүхий 14 үзүүлэлт	+	+		
3	3	Биохимийн шинжилгээ	Элэгний үйл ажиллагаа	билирубин	+	+	
	4			АСАТ	+	+	
	5			АЛАТ	+	+	
	6			сахар	+	+	
	7			амилаза	+	+	
	8			Гаммаглутамилтрансфераза /ГТТ/	+		
	9			иммунологийн шинжилгээ	ASLO	+	+
	10				CRB	+	+
	11		RF		+	+	
	12		өөх тосны солилцоо	холестрин	+	+	
	13			триглицерид	+	+	
	14		эрдсийн солилцоо	кали	+	+	
	15			кальци	+	+	
16	төмөр				+		
17	вирусийн маркер		В вирус	+	+		
18			С вирус	+	+		
19			хелико бактери	+	+		
4	20		Бамбай булчирхайн шинжилгээ	TSH	+	+	
5	21		Багажийн шинжилгээ	ЭХО элэг, цэс, нойр булчирхай, дэлүү, бөөр, умай, дайвар /эм/, түрүү булчирхай /эр/	+	+	
6	22	Эмчийн үзлэг		+	+		


Нийгмийн даатгалын үндэсний  
зөвлөлийн 2014 оны 05 дугаар  
сарын 28-ны өдрийн 77 тоот  
тогтоолын хоёрдугаар хавсралт



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИЙГ УРАМШУУЛАХ ҮЗЛЭГИЙН  
ОНОШЛОГОО, ШИНЖИЛГЭЭНИЙ ХОЁРДУГААР БАГЦ**

№		ҮЗЛЭГ ШИНЖИЛГЭЭ		ДААТГУУЛАГЧИЙН ХҮЙС		
				эрэгтэй	эмэгтэй	
1	1	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ	ЦЕШ, цусны бүлэгнэлт, цагаан эс тоолох /тромбоцит бүхий 22 үзүүлэлт/	+	+	
2	2	Биохимийн шинжилгээ	Элэгний үйл ажиллагаа	билирубин	+	+
	3			АСАТ	+	+
	4			АЛАТ	+	+
	5			сахар	+	+
	6		Вирусийн маркер	В вирус	+	+
	7			С вирус	+	+
	8			хелико бактери /цусанд/	+	+
3	9		Багажийн шинжилгээ	ЭХО	элэг, цөс, нойр булчирхай, дэлүү, бөөр, умай, дайвар /эм/, түрүү булчирхай /эр/	+
4	10	Хавдрын шинжилгээ	PSA /түрүү булчирхай/		+	
	11		СА-72-4 /ходоод, нойр булчирхай, уушиг, хөх/		+	+
5	12	Эмэгтэйчүүдийн шинжилгээ	Умайн хүзүүний эсийн шинжилгээ			+
6	13		Үтрээний наалдцын шинжилгээ			+
7	14	Эмчийн үзлэг		+	+	

Нийгмийн даатгалын үндэсний  
зөвлөлийн 2014 оны 05 дугаар  
сарын 28-ны өдрийн 17 тоот  
тогтоолын хоёрдугаар хавсралт



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИЙГ УРАМШУУЛАХ  
ҮЗЛЭГИЙН ОНОШЛОГОО, ШИНЖИЛГЭЭНИЙ ГУРАВДУГААР БАГЦ**

№		ҮЗЛЭГ ШИНЖИЛГЭЭ		ДААТГУУЛАГЧИЙН ХҮЙС		
				эрэгтэй	эмэгтэй	
1	1	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ	ЦЕШ, цусны бүлэгнэлт, цагаан эс тоолох /тромбоцит бүхий 22 үзүүлэлт/	+	+	
2	2	Биохимийн шинжилгээ	Элэгний үйл ажиллагаа	АСАТ	+	+
	3			АЛАТ	+	+
	4			Гаммаглутамилтрансфераза /ГГТ/	+	+
	5		сахар	+	+	
	6		вирусийн маркер	В вирус	+	+
	7			С вирус	+	+
	8			хелико бактери /цусанд/	+	+
3	9	Харшлын шинжилгээ	Харшил (хүнсний) эсвэл (амьсгалын замын) 10 үзүүлэлт	+	+	
4	10	Серологийн шинжилгээ		+	+	
5	11	Эмчийн үзлэг		+	+	

Нийгмийн даатгалын үндэсний  
зөвлөлийн 2014 оны 05 дугаар  
сарын 28 өдрийн 17 тоот  
тогтоолын гуравдугаар хавсралт

## ДААТГУУЛАГЧИЙГ УРАМШУУЛАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЭМНЭЛГҮҮДИЙГ СОНГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ жил бүр тогтмол төлсөн, дараалсан гурван жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ аваагүй даатгуулагчийг эрүүл мэндийн бүрэн үзлэгт нэг удаа хамруулж, урамшуулах үзлэгийг (цаашид “даатгуулагчийг урамшуулах үзлэг” гэх) зохион байгуулах эмнэлгүүдийг сонгоход энэхүү журмыг баримтална.

1.2. Даатгуулагчийг урамшуулах үзлэгийг зохион байгуулах эмнэлгүүдийг сонгох үүргийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар байгуулсан комисс (цаашид “комисс” гэх) гүйцэтгэнэ.

1.3. Комисс нь дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна. Комиссын бүрэлдэхүүнд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яамтай тус тус зөвшилцсөнөөр, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газар, эмнэлэг, төрийн бус байгууллага, даатгуулагчийг төлөөлсөн тус бүр 1 хүн байна.

1.4. Даатгуулагчийг урамшуулах үзлэгийг энэ журмын гуравдугаар хэсэгт заасан шалгуур үзүүлэлтүүдийг хангаж, комиссын шийдвэрээр батлагдсан эмнэлэг үзүүлнэ.

### Хоёр. Нийгмийн даатгалын байгууллагын үүрэг

2.1. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь энэ журмын 1.2-т заасан комиссыг байгуулан ажиллуулж, эмнэлэг сонгон шалгаруулах ажлыг жил бүрийн 11 дүгээр сард багтаан явуулж, эмнэлгүүдийн нэр, байршлын мэдээллийг дараа оны 01 дүгээр сарын 05-ны дотор нийтэд мэдээлнэ.

2.2. Комисс нь сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийн үнэлгээг үндэслэн, сонгон шалгаруулалтыг шударга, ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах зарчим баримтлана.

2.3. Комисс сонгон шалгаруулалт явуулах тухай урилгыг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас, Нийгмийн даатгалын хэлтсээр дамжуулан зарлана.

### Гурав. Даатгуулагчийг урамшуулах үзлэгийг зохион байгуулах эмнэлгүүдийг сонгох шалгуур үзүүлэлтүүд

3.1. Сонгон шалгаруулалтад оролцох эмнэлгүүдэд тавигдах шаардлагад эмнэлгийн бүтэц, хүчин чадал, тусламж, үйлчилгээний чанар, эмч,



мэргэжилтнүүдийн мэргэшил, ур чадварын үзүүлэлтийг хамааруулах бөгөөд эдгээрийг үнэлэх шалгуур нь эмнэлэг бүрт ижил байна.

3.2. Даатгуулагчийг урамшуулах үзлэгийн оношлогоо, шинжилгээний багцыг даатгуулагчид чанартай, аюулгүй, хүртээмжтэй, нэмэлт төлбөргүйгээр үзүүлэх тусгай зөвшөөрөл, хүчин чадал бүхий энэ журмын 3.3-т заасан шаардлагыг хангах зорилгоор 2-3 эмнэлэг /тухайлбал, хувийн эмнэлэг, рентген, лабораторитой хамтарч/ хамтран сонгон шалгаруулалтад оролцож болно.

3.3. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргасан эмнэлэг нь дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:

Шалгуур үзүүлэлтүүд		Мэдээллийн эх үүсвэр	Үнэлгээ
1	Эрүүл мэндийн үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөлтэй байх	Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	
2	Магадлан итгэмжлэгдсэн байх	Батламж	
3	Эмнэлгийн зориулалтын байранд үйл ажиллагаа явуулдаг байх	Эзэмшлийн гэрчилгээ болон түрээсийн гэрээ	
4	Мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гаргуулсан байх	Мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдлийн үнэлгээний дүгнэлт	
5	Нийгмийн даатгалын шимтгэлийг тогтмол төлдөг, ажилтнуудаа даатгалд бүрэн хамруулдаг байх	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тухайн жилийн тайлангийн хуулбар	
6	Нийт ажилтны 90-ээс доошгүй хувь нь үндсэн ажилтан байх	Байгууллагын даргын тушаал, хөдөлмөрийн гэрээ	
7	Эмнэлгийн чанарын албаны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж дүгнэсэн байх	Чанарын албанаас хийх жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан /Сүүлийн 2 жилийн тайлан/	
8	Багцад заасан тусламж, үйлчилгээг үзүүлэх хүний нөөцтэй байх	Мэргэжилтнүүдийн лиценз, мэргэжлийн болон мэргэшлийн ур чадварын батлагаа	
9	Сонгон шалгаруулалтад заагдсан тусламж, үйлчилгээ үзүүлэх, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, орчин үеийн тоног төхөөрөмжтэй байх	Тоног төхөөрөмжийн жагсаалт, эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж, бодисын ханган нийлүүлэх гэрээ	
10	Лабораторийн дотоод, гадаадын баталгаажуулалтыг хийлгэдэг байх	Сүүлийн жилийн баталгаажуулалтын хуулбар	

### Дөрөв. Даатгуулагчийг урамшуулах үзлэгийг зохион байгуулах эмнэлгийг үнэлэх, сонгох

4.1. Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн эмнэлэг нь урилгад заасан хугацаанд шалгуур үзүүлэлт тус бүрээр дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

Д/д	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт
1	Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн албан хүсэлт (Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайдын 2013 оны 459/280/182 тоот хамтарсан тушаалаар баталсан хувьсах зардлын хэмжээг хүлээн зөвшөөрсөн эсэхийг албан хүсэлтэд дурдах)
2	Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
3	Магадлан итгэмжлэлийн батламжийн хуулбар
4	Эмнэлгийн байрны эзэмшлийн, эсхүл түрээсийн гэрээний хувь
	Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой

5	тушаал, шийдвэрүүд, бүтэц, үйл ажиллагаа болон оношлогоо, эмчилгээний стандартын жагсаалт, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамж, чанар, аюулгүй байдлын талаар мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт, тайлан
6	Эмнэлгийн бүтэц, орон тоог баталсан шийдвэр, эмч, мэргэжилтнүүдийг ажилд томилсон шийдвэр, ажиллагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан
7	Сонгон шалгаруулалтад заагдсан тусламж, үйлчилгээг үзүүлэх мэргэшсэн хүний нөөц, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн нөөцийн хангалтын талаархи мэдээлэл;
8	Харьяа Эрүүл мэндийн газрын дүгнэлт;
9	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын албаны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан
10	Эмнэлгийн бүтэц, зохион байгуулалтын танилцуулга

4.2. Сонгон шалгаруулах комисс нь хүсэлт гаргасан эмнэлгийн энэ журмын 4.1-д заасан баримт бичгийг хүлээн авч, бүрдэл, тавигдсан шаардлага хангасан эсэхийг үндэслэн энэ журмаар тогтоосон аргачлалын дагуу үнэлгээ хийж, “тэнцсэн” эсхүл “тэнцээгүй” гэсэн үнэлгээ өгнө.

4.3. Комисс нь даатгуулагчийг урамшуулах үзлэгийг зохион байгуулах шаардлагыг хангаж, “тэнцсэн” үнэлгээ авсан эмнэлгүүдээс онооны жагсаалт, орон нутгийн онцлог, үйлчилгээний хүртээмж зэргийг харгалзан сонгож, холбогдох шийдвэрээ гаргана.

4.5. Комисс нь сонгон шалгаруулалтад тэнцсэн эмнэлгүүдийн нэрсийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудсаар дамжуулан энэ журмын 2.1-д заасан хугацаанд багтаан нийтэд мэдээлнэ.

4.6. Нийгмийн даатгалын байгууллага нь урамшууллын тусламж, үйлчилгээ үзүүлэхээр хүсэлт ирүүлсэн эрүүл мэндийн байгууллагын талаарх мэдээллийг харьяа мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газраас нэгдсэн журмаар гаргуулан авна.

#### **Тав. Эмнэлгийн үүрэг**

5.1. Эмнэлэг нь даатгуулагчийг урамшуулах үзлэгийг зохион байгуулах сонгон шалгаруулалтад орох хүсэлтээ энэ журмаар тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох баримт бичгийн хамт Комисст шуудангаар болон биечлэн хүргүүлнэ.

5.2. Сонгон шалгаруулалтад орохыг хүсэгч эмэнэлэг нь энэ журмын 4.1-д заасан баримт бичгийг хуурамчаар үйлдэхийг хориглоно.

5.3. Эмнэлэг нь сонгон шалгаруулалтад тэнцсэн тохиолдолд урамшуулах үзлэгийг даатгуулагчид тэгш, хүртээмжтэй, чанартай, гомдол чирэгдэлгүй /дараалал харгалзахгүй, дарааллыг урьдчилан бүртгэж хуваарилах, хөтөч дагуулах гэх зэрэг/, нэмэлт төлбөргүйгээр үзүүлж тэдэнд хүндэтгэлтэй хандана.

#### **Зургаа. Хариуцлага**

6.1. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд буруутай байгууллага, албан тушаалтан, даатгуулагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.